

АШИГТ МАЛТМАЛЫН ГАЗАР

**МОНГОЛ УЛСЫН УУЛ
ҮҮРХАЙН САЛБАРЫН
ТАТВАРЫН ХУУЛЬ
ЭРХ ЗҮЙН ОРЧИН БА
ТАТВАРЫН АЧААЛЛЫН
СУДАЛГАА**



2011 он

LB	-0.93	-0.7%
MAL	-0.61	-0.5%
NE	-0.07	-0.05%
MV	-0.52	-1.58%
OTVV	-0.31	-3.22%
HYOS	-0.04	-0.18%
PLUG	-0.05	-0.54%
ESLR	-0.11	-0.54%
LMT	-0.04	-0.19%
	11.61	0.11
	21.19	0.04
	26.37	-0.01
	62.20	-0.04%
	21.77	0.53
	26.6	0.13



Зохиогчид:

Судалгааны ажлыг удирдсан:

АМГ, УУСХ, СМСТ-ийн дарга
АМГ, УУСХ, СМСТ-ийн ахлах мэргэжилтэн

Б.Бямбадагва
Ц.Цэгц

Судалж гүйцэтгэсэн:

АМГ, УУСХ, СМСТ-ийн мэргэжилтэн
АМГ, УУСХ, СМСТ-ийн мэргэжилтэн

Д.Маасүрэн
Б.Сүхтулга

Хаяг:

Монгол Улс, Улаанбаатар 211238, Шуудангийн салбар 38,
Барилгачдын талбай 3, Засгийн газрын XII байр,
Баруун жигүүр, Ашигт Малтмалын Газар,
Уул уурхай, судалгааны хэлтэс

Утас: 976-11-263709

Факс: 976-11-310041

E-mail: maa_davaa@yahoo.com

Web page: <http://www.mram.gov.mn>

1	2	3
1	2	3
1	2	3
1	2	3
1	2	3



3

АГУУЛГА

Удиртгал

1. Монгол Улсын Уул уурхайн салбарын татварын эрх зүйн орчин
2. Монгол Улсын Уул уурхайн салбарын татварын ачааллын судалгаа
3. Олон Улсын Уул уурхайн салбарын татварын орчны судалгаа
 - 1.1. Олон Улсын Уул уурхайн салбарын татварын эрх зүйн орчин
 - 1.2. Олон Улсын Уул уурхайн салбарын татварын ачааллын судалгаа
4. Монгол Улсын Уул уурхайн салбарын өнөөгийн байдал ба татварын шинэчлэлт
 - 4.1 Монгол Улсын Уул уурхайн салбарын өнөөгийн байдал
 - 4.2 Монгол улсын Уул уурхайн салбарын татварын шинэчлэлт
 - 4.2.1 Зарим бүтээгдэхүүний үнийн ёсөлтийн албан татварын судалгаа
 - 4.2.2 Австрали улсын ашигт малтмалын нөөц ашигласны төлбөр, шинээр хэрэгжиж гарсан ашигт малтмалын төлбөрийн судалгаа
 - 4.2.3 Монгол Улсын Уул уурхайн салбарын татварын шинэчлэлтийн судалгаа

Дүгнэлт

Ашигласан ном, материал

LB	-0.93	-0.7%
MAL	-0.61	-0.5%
NE	-0.07	-0.05%
MV	-0.52	-1.58%
OTVV	-0.31	-3.22%
HYOS	-0.04	-0.18%
PLUG	-0.05	-0.5%
ESLR	21.61	0.11
LMT	21.19	0.04
	26.37	-0.01
	62.20	-0.04%
	21.77	0.53
	26.6	0.13



•УДИРТГАЛ•

Эх орныхоо эрдэс баялгийн үр өгөөжийг ард түмнийхээ хүртээл болгох гол хөшүүрэг нь татварын тогтолцоо, түүгээр дамжин төвлөрсөн мөнгөн сан болох төрийн сан төсөвт орж буй орлогын хэмжээгээр хэмжигдэх зүй тогтолтой билээ.

Эрдэс баялгийнхаа ашиглалтаас ард түмэндээ хүртээх ойлголт, хэлбэрүүд эрдэс баялгийн нөөц бүхий ихэнх орууладад байдаг ба үүний нэг тод жишээ бол Кувейт улс юм. Кувейт улс нефтийн баялаг ихтэй орон бөгөөд түүний олборлолт, борлуулалтаас олсон орлогын нилээд хэсгийг ирээдүйн иргэддээ зориулан хуримтлал болгон үлдээдэг билээ.

Сүүлийн жилүүдэд дэлхийн зах зээл дээрхи ашигт малтмалын бүтээгдэхүүний үнэ ханш нилээдгүй өсч, энэ хирээр Монгол Улсын уул уурхайн, эрдэс баялгийн салбарт оруулах гадаад, дотоодын хөрөнгө оруулалт ч өссөөр ирсэн билээ. Мөн ойрын жилүүдэд стратегийн ач холбогдол бүхий ашигт малтмалын орд газрууд эдийн засгийн эргэлтэд орж, Монгол Улсын уул уурхайн үйлдвэрлэл цаашид хурдацтайгаар өсөхөөр байна. Энэ нөхцөл байдлаас харахад манай улсын эдийн засаг, төсөв уул уурхайн салбараас ихээхэн хамааралтай болох нь тодорхой байна. Иймээс уул уурхайн үйлдвэрлэлээс бий болсон ашгаас хөрөнгө оруулагчдад татварын дарамт учруулахгүйгээр, нөгөө талаас Монгол Улс баялгийн эзний хувьд уул уурхайн үйлдвэрлэлийн ашгийн боломжийн, шударга үр өгөөжийг хүртэх асуудал зүй ёсоор тавигдаж байна.

Энэхүү судалгааны ажлаараа улс орны эдийн засгийн чухал салбарын нэг болох уул уурхайн салбарыг хөгжүүлэхэд татварын бодлогоор дэмжих, уул уурхайн татварын тогтолцоог дэлхийн

SLB	-0.33	-0.01
HAL	-0.07	-0.02
NE	-0.01	-0.02
MV	-0.01	-0.02
OTVV	-0.04	-0.18%
HYOS	-0.05	-0.54%
PLUG	-0.11	-0.34%
ESLR	-0.04	-0.19%
LNTT	-0.01	-0.01
21.36	-0.05	-0.44%
21.32	-0.02	-0.08%
21.31	-0.01	-0.02%
21.30	-0.04	-0.12%
21.29	-0.01	-0.02%
21.28	-0.01	-0.02%
21.27	-0.04	-0.19%
21.26	-0.01	-0.04%
21.25	0.53	0.86%
21.24	0.13	0.07%

хөгжингүй болон хөгжиж буй зарим орнуудад хэрхэн хөгжүүлж буй, түүнийг Монгол Улсын уул уурхайн салбарт хэрэгжүүлэх боломжийг судалж, тодорхой санал дэвшүүлэхийг зорилоо.

1. Уул уурхайн салбарын татварын эрх зүйн орчин

Татвар бол улс орны орлогын урсгал төсвийн бүрдүүлэлтийн үндэс юм. Иймээс үйлдвэрлэл эрхлэгч аж ахуйн нэгжүүд татварын бүтэц, ногдуулалтандaa тодорхой хугацаагаар шинжилгээ зайлшгүй хийдэг. Татвар, төлбөр, хураамж /тариф суутгал/ бол үйлдвэрлэж байгаа бүтээгдэхүүний үнэ бүрэлдэх нэг гол нөхцөл байдаг. Үйдвэрлэлийн зардал, татвар төлөлт, үнэ бол зах зээлд бүтээгдэхүүнээ үнэлэх, ашгаа тогтоох гол хэмжүүрүүдийн нэг билээ.

Монгол Улсын Уул уурхайн салбарын үйл ажиллагааг зохицуулах дараахь хуулиуд хэрэгжиж байна.

Үүнд:

- Аж ахуйн үйл ажиллагааны тусгай зөвшөөрлийн тухай хууль
- Аж ахуйн нэгжийн орлогын албан татварын тухай хууль
- Ашигт малтмалын тухай хууль
- Байгаль орчныг хамгаалах тухай хууль
- Байгаль орчинд нөлөөлөх байдлын үнэлгээний тухай хууль
- Байгалийн нөөц ашигласны төлбөрийн орлогоос байгаль орчныг хамгаалах, байгалийн нөөцийг нөхөн сэргээх арга хэмжээнд зарцуулах хөрөнгийн хувь, хэмжээний тухай хууль
- Гадаадын хөрөнгө оруулалтын тухай хууль
- Гаалийн тариф, гаалийн татварын тухай хууль
- Гаалийн албан татвараас чөлөөлөх тухай хууль

LB	-0.93	-0.7%
MAL	-0.61	-0.5%
NE	-0.07	-0.0%
MV	-0.52	-1.5%
OTVV	-0.31	-3.2%
HYOS	-0.04	-0.1%
PLUG	-0.05	-1.3%
ESLR	-0.11	-0.4%
LMT	-0.04	-0.1%
	11.61	0.11
	21.19	0.04
	26.37	-0.01
	62.20	-0.04%
	21.77	0.53
	26.6	0.13

- Гаалийн болон нэмэгдсэн өртгийн албан татвараас чөлөөлөх тухай хууль
- Газрын хэвлийн тухай хууль
- Газрын тухай хууль
- Газрын төлбөрийн тухай хууль
- Гол, мөрний урсац бүрэлдэх эх, усны сан бүхий газрын хамгаалалтын бүс, ойн сан бүхий газарт ашигт малтмал хайх, олборлохыг хориглох тухай хууль
- Зарим бүтээгдэхүүний үнийн өсөлтийн албан татварын тухай хууль
- Нэмэгдсэн өртгийн албан татварын тухай хууль
- Ойн тухай хууль
- Татварын ерөнхий хууль
- Ус рашааны нөөц ашигласаны төлбөрийн тухай хууль
- Усны тухай хууль
- Үл хөдлөх эд хөрөнгийн албан татварын тухай хууль
- Цөмийн энергийн тухай хууль бусад холбогдох хууль тогтоомжийн баримт бичгүүд гэх мэт.

Монгол Улсын уул уурхайн салбарт үйл ажиллагаа явуулж буй аж ахуйн нэгжүүд нь дараах татвар, төлбөр, хураамжийг улсын болон орон нутгийн төсөвт оруулдаг.

Үүнд:

1. Аж ахуйн нэгжийн орлогын албан татвар
2. Ашигт малтмалын нөөц ашигласны төлбөр
3. Авто тээврийн болон өөрөө явах хэрэгслийн албан татвар
4. Хайгуулын болон ашиглалтын тусгай зөвшөөрлийн төлбөр
5. Нэмэгдсэн өртгийн албан татвар
6. Импортын барааны гаалийн татвар
7. Онцгой албан татвар
8. Зарим бүтээгдэхүүний үнийн гэнэтийн өсөлтийн албан татвар

9. Үл хөдлөх эд хөрөнгийн албан татвар
10. Газар ашигласны төлбөр
11. Ус ашигласны төлбөр
12. Зам ашигласны төлбөр
13. Ойгоос хэрэглээний мод, түлээ бэлтгэж, ашигласны төлбөр
14. Түгээмэл тархацтай ашигт малтмалын нөөц ашигласны төлбөр
15. Гадаадын мэргэжилтэн, ажилчны ажлын байрны төлбөр
16. Гаалийн үйлчилгээний хураамж
17. Орон нутгийн төсөвт төлсөн тэмдэгтийн хураамж
18. Төрийн захиргааны орон нутгийн байгууллагад төлсөн үйлчилгээний хөлс гэх мэт.

Үл уурхайн салбарт хэрэгжиж буй татварын хувь хэмжээний өөрчлөлт нь уул уурхайн салбарын үйлдвэрлэл, мөн гадаад дотоодын хөрөнгө оруулалтын хэмжээнд шууд хамааралтай байдаг.

Монгол Улсад хүчин төгөлдөр байгаа татвар, төлбөр хураамж, тэдгээрийн хувь хэмжээг хүснэгт 1-д харуулав.

Хүснэгт 1

Монгол Улсын Үул Уурхайн салбарын татварын орчны судалгаа							
д/д	Хууль болон татварын төрөл	2003 он	2004-2005 он	2006 он	2007* он	2008-2010 он	2011 он
1.	Хайгуулын лицензийн төлбөр /ам.доллар/гектор/						
	1 жил	0,01		0,1	0,1	0,1	
	2 жил	0,5		0,2	0,2	0,2	
	3 жил	0,5		0,3	0,3	0,3	
	4-6 жил	1		1	1	1	
	6 жил	1,5		1	1	1	
	7-9 жил	1,5		1,5	1,5	1,5	
2.	Ашиглалтын тусгай зөвшөөрлөйн төлбөр /ам.доллар/гектор/						
	1-3 жил	5		Жил харгалзахгүй 15\$ байх бөгөөд			
	4-6 жил	7,5		нүүрс болон түгээмэл тархацтай ашигт			
	7 ба түүнээс дээш жил			малтмалын хувьд гектар тутамд 5\$ байна.			
		10					

LB	-0.53	-0.7%
MAL	-0.61	-0.7%
NE	-0.07	-0.0%
MV	-0.52	-0.5%
OTVV	-0.31	-0.3%
HYOS	-0.04	-0.1%
PLUG	-0.04	-0.1%
ESLR	-0.01	-0.1%
LMT	-0.53	-0.7%
	0.13	0.6%
	26.6	0.6%

3.	Ашигт малтмалын нөөц ашигласны төлбөр	Алтны үндсэн ордод 2,5%, шороон ордод 7,5%, бусад ордод 2,5%	Дотоодод борлуулж байгаа нүүрс болон түгээмэл тархацтай ордод 2,5%, бусад ашигт малтмал болон экспортод гаргаж байгаа бүтээгдэхүүнд 5%		
4.	Зарим бүтээгдэхүүний үнийн өсөлтийн албан татвар			Зэсийн баяжмал болон алтны дэлхийн зах зээлийн үнэ зэсэнд 2600\$/тн, алтанд 500\$/унци-аас дээш дээш болсон тохиолдол үүнээс дээш гарсан үнийн дүнгийн зөрүүнээс олсон орлогод 68%-ийн татвар ноогдуулна.	Зэсийн баяжмалд 2600\$/тн, алтанд 850\$/унци-аас дээш гэж өөрчилсөн. 2011 оны 1-р сарын 1-ний өдрөөс хүчингүй болно.
5.	Хүн амын орлогын албан татвар	200 мянга хүртэл 10%, 200-400 мянга хүртэл 30%, 400 мянгаас дээш 30%	Шатлал харгалзахгүй 10%		
6.	Аж ахуйн нэгж, байгууллагын орлогын албан татварын тухай хууль	0-100 сая-15%, >100сая-40%	0-100 сая-15%, >100сая-30%	0-3 тэрбум -10%, > 3 тэрбум-25%	
7.	Нэмэгдсэн өргтийн албан татвар	>10 сая-15%, <10 сая 0%, Алт-0%		Шатлал харгалзахгүй 10%, Алт-0%	
8.	Үл хөдлөх хөрөнгийн татвар	2%			
9.	Автобензин, дизель, тулшиний албан татвар	Автобензин-90 хүртэл октантай-20350 төг/тн, 90-ээс дээш октантай-25700 төг/тн, дизель тулш-2140 төг/тн.			
10.	Үс ашигласны төлбөр	Гадаргын болон гар худгийн 1-5 төг/м3, газрын гүний үс /үйлдвэрлэл/-1-20 төг/м3	Газрын гадаргын ба гүний үс 100-150 төг/м3		
11.	Газрын ашигласны төлбөр	Тухайн орон нутгийн төрийн байгууллагын тодорхойлсон үнэлгээний 0,01-0,03 хувиар тэрхүү орон нутгийн төсөвт төлнө.			


* Ашигт малтмалын тухай хуулинд шинэчилсэн найруулга хийж 2007 оны 7 сараас, Зарим бүтээгдэхүүний үнийн өсөлтийн албан татварын тухай хуулийг 2006 оны 5 сараас хэрэгжүүлж эхэлсэн

AL	-0.33
NE	-0.07
MV	-0.32
OTVV	-0.01
HYOS	-1.22%
PLUG	-0.04
ESLR	-0.01
LNT	-0.05
26	-0.01
11	-0.04
36	-0.01
21	-0.11
26	-0.04
62	-0.01
21	-0.53
77	0.13
26	0.86%

2. Уул уурхайн салбарын татварын ачааллын судалгаа

Татварын ачаалал гэдэг нь нийт татварын хэмжээг борлуулалтын орлогод харьцуулсан хувь хэмжээгээр илэрхийлэгдэнэ.

Уул уурхайн салбарын гол нэр төрлийн ашигт малтмалын хувьд татварын ачааллын түвшинг тооцож ашигт малтмал тус бүрээр харуулав.




1-р зураг. Татварын ачаалал

Үүнээс үзэхэд 2009 онд зэсийн баяжмалын татварын ачаалал 45,5%-тай хамгийн өндөр нь байхад цайрын баяжмалын татварын ачаалал 11,3% -тай хамгийн бага нь байна. Алт, гянтболдын баяжмал, төмрийн хүдэрийн татварын ачаалал дундаж түвшин буюу 13,1-26,4%-тай байна. Энэ нь зарим бүтээгдэхүүний үнийн өсөлтийн албан татварын хуулиар алт, зэсэнд гэнэтийн ашгийн татвар ноогдуулсантай холбоотойгоор зэсний татварын ачаалал өндөр байна.

Зарим бүтээгдэхүүний үнийн өсөлтийн албан татвартай холбоотойгоор татварын ачааллын түвшин нэмэгдсэн бөгөөд 2008, 2009 онд алтны компаниудын дампуурал болон далд эдийн засаг бий болж, валютын хомсдолоос инфляцийн түвшин нэмэгдэх хандлага ажиглагдсан гэж үзэж байна.


2006-2009 оны алт үйлдвэрлэлийн татварын ачааллын шинжилгээг хийж үзлээ.



2-р зураг. Алтны үйлдвэрлэлийн татварын ачаалал

Үүнд: 2007 онд 28,03%, 2008 онд 34,33% болж алтны ачааллын хэмжээ өссөн байна. Энэ нь 2008 оны 11 сарын 25-ны өдрийн зарим бүтээгдэхүүний үнийн өсөлтийн албан татварын хуулиар өөрчлөлт орж алтны босго үнийг 1 унци алтны үнэ 850 ам доллар болж өөрчлөгдсөнтэй холбоотойгоор 2009 онд татварын ачаалал буурсан нь харагдаж байна.

Уул уурхайн салбарын татварын гол нэр төрлөөр нь татварын орлогыг харуулбал :



3-р зураг. Голлох татварын бүтэц

Ашигт малтмалын нөөц ашигласны төлбөр нь 2007-2009 оны хооронд тогтмол өсөлттэй байгаа нь нүүрс, тэмрийн хүдэр зэрэг бүтээгдэхүүний гаргалт өссөнтэй холбоотой бол зарим бүтээгдэхүүний үнийн өсөлтийн албан татвар нь 2009 онд өмнөх онтой харьцуулахад 20.7 %-иар буурсан нь ихэнх алтны олборлогч аж ахуйн нэгжийн монгол банкинд тушаах алтны хэмжээ багассантай холбоотой байна.



3.Олон улс дахь уул уурхайн салбарын татварын орчны судалгаа

3.1.Олон Улсын уул уурхайн салбарын татварын эрх зүйн орчин

Татварын эрх зүй нь татвар ногдуулах хүрээн дэх нийгмийн тодорхой харилцаа бөгөөд татвар төлөгчдийн орлогоос улсын төсвийг бүрдүүлэгч эх үүсвэрийг зохицуулдгийн хувьд, татварын эрх зүйн актуудаар баталгаажсан заавал биелүүлэх, засаглалын шинжийг агуулж байдаг.

Гадаадын өндөр хөгжилтэй орнуудын татварын хуулинд тусгагдсан уул уурхайн салбарт хэрэглэгддэг зарим төрлийн татварыг авч үзвэл:

Хүснэгт-2

Олон Улсын Уул Уурхайн салбарын татварын орчны судалгаа

д/д	Улс орнуудын нэр	Орлогын албан татвар, %	НӨАТ, %	Татварын тогтвортой байдал	ЭХШ / жил/	Алдагдлыг ирээдүйд шилжүүлэх	АМНАТ, %	Импортын татвар, %	Ноогдол ашгаас сутгах татвар, %	Албан татварын нийт хэмжээ, %
1	Аргентин	35	-	+	3*	+	+	-	-	40
2	Австрали	30	-	-	-	+	+	5	30	36,4
3	Канад	29,12	7	+	+	+	+	0,5	25	29,2
4	Чили	15/42	18	+	3*	+	+	10	35	49,2
5	Хятад	33	17	-	10	+	+	-	-	41,7
6	Гана	35	-	-	+	+	+	-	10	54,4
7	Гринланд	35	-	-	+	+	+	-	35	50,2
8	Индонези	30	10	+	-	+	+	-	20	46,1
9	Казакстан	30	-	+	+	+	+	-	15	46,1
10	Лаос	-	-	+	-	-	+	-	-	35

SLB	-0.33	-0.01	-0.06	-0.11	-0.11	-0.06	-0.06	-0.06	-0.06	-0.06
MAL	-0.36	-0.07	-0.06	-0.06	-0.06	-0.06	-0.06	-0.06	-0.06	-0.06
NE	-0.32	-0.04	-0.06	-0.06	-0.06	-0.06	-0.06	-0.06	-0.06	-0.06
MV	-0.34	-0.02	-0.06	-0.06	-0.06	-0.06	-0.06	-0.06	-0.06	-0.06
OTVV	-0.28	-0.01	-0.06	-0.06	-0.06	-0.06	-0.06	-0.06	-0.06	-0.06
HYOS	-0.13	-0.04	-0.10	-0.06	-0.06	-0.06	-0.06	-0.06	-0.06	-0.06
PLUG	11.61	-0.05	-1.24%	0.67	1.11	-0.06	-0.06	-0.06	-0.06	-0.06
ESLR	21.17	-0.11	-0.54%	0.71	1.31	-0.06	-0.06	-0.06	-0.06	-0.06
LNTT	26.37	-0.04	-0.34%	0.61	1.2	-0.06	-0.06	-0.06	-0.06	-0.06
	62.20	-0.01	-0.19%	0.0	0.7	-0.06	-0.06	-0.06	-0.06	-0.06
	21.77	0.53	0.86%	0.07	0.7	-0.06	-0.06	-0.06	-0.06	-0.06
	26	0.13	0.06%	0.0	0.0	-0.06	-0.06	-0.06	-0.06	-0.06


11	Монгол	10/25	10	+	5*	+	2,5/5	5	20	32,9
12	Мексик	35	15	+	-	+	+	-	35	49,9
	Папуа									
13	Шинэ Гвиней	30	-	+	+	+	+	-	10	42,7
14	Перу	27	18	+	5*	+	+	12	4,1	46,5
15	Польш	22	22	-	5*	+	+	9	20	49,6
16	Өмнөд Африк	30	14	-		+	+	-	12,5	45
17	Швед	28	25	-	5*	+	+	-	-	28,6
18	АНУ	38,3	-	-	-	+	+	-	30	49,9
19	Узбекистан	33	-	+	-	-	+	-	15	62,9
20	Зимбабве	35	-	-	+	+	+	5	20	39,8

Тайлбар: + ийм төрлийн татвар байдаг
- ийм төрлийн татвар байдаггүй

3.2.Олон Улсын уул уурхайн салбарын татварын ачааллын судалгаа

Монголын уул уурхайн салбарын албан татварын нийт хэмжээг олон улсын уул уурхайн салбарын албан татварын нийт хэмжээтэй харьцуулж үзвэл:

Олон улсын уул уурхайн салбарын албан татварын нийт хэмжээ



4-р зураг. Олон Улсын уул уурхайн салбарын албан татварын нийт хэмжээ

Олон улсын хэмжээнд уул уурхайн салбарын албан татварын нийт хэмжээгээр Узбекстан хамгийн өндөр хувьтай буюу 62,9%, хамгийн бага нь 28,6% -тай Швед улс байх бөгөөд Монгол улс 32,9%-тай байгаа нь Олон Улсын уул уурхайн салбарын хувьд дундаж хэмжээнд байгаа нь харагдаж байна.

4. Монгол Улсын Уул уурхайн салбарын өнөөгийн байдал ба татварын шинэчлэлт

4.1. Монгол Улсын Уул уурхайн салбарын өнөөгийн байдал

Монгол Улсын уул уурхайн салбар 2010 онд зэсийн баяжмал, молибдений баяжмал, жоншны баяжмал, бүхэллэг жонш, алт, нүүрс,

AL	-0.33	-0.07	-0.07	-0.07	-0.07	-0.07
NE	-0.36	-0.07	-0.07	-0.07	-0.07	-0.07
MV	-0.34	-0.01	-0.01	-0.01	-0.01	-0.01
OTVV	-0.28	-0.01	-0.01	-0.01	-0.01	-0.01
HYOS	-0.13	-0.04	-0.11	-0.11	-0.11	-0.11
PLUG	11.61	0.05	-0.54%	-0.54%	-0.54%	-0.54%
ESLR	21.17	-0.11	-0.34%	-0.34%	-0.34%	-0.34%
LINT	26.37	-0.04	-0.19%	-0.19%	-0.19%	-0.19%
LI	62.20	-0.01	-0.04%	-0.04%	-0.04%	-0.04%
LI	21.77	0.53	0.86%	0.86%	0.86%	0.86%
LI	26	0.13	0.07	0.07	0.07	0.07

катодын зэс, гянтболдын баяжмал, төмрийн хүдэр, давс, барилгын материалын түүхий эд үйлдвэрлэсэн бөгөөд Аж үйлдвэрийн салбарын нийт үйлдвэрлэлт 2010 оны 11 сарын 01-ны байдлаар 3 242 911.1 сая төгрөг байснаас Уул уурхайн салбар 2 255 253.4 сая төгрөгний бүтээгдэхүүн үйлдвэрлэсэн нь өмнөх оны мөн үетэй харьцуулахад 59.8%-иар өссөн байна. Улсын нийт экспортын хэмжээ 2010 оны 12 сарын 01-ны байдлаар 2 550 648.2 мянган ам.доллар болж үүний 2 045 121.8 мянган ам.доллар нь уул уурхайн бүтээгдэхүүний экспорт эзэлж байна.

Уул уурхайн салбарт олборлолтын үйл ажиллагаа явуулж буй аж ахуйн нэгжүүдээс улс, орон нутгийн төсөвт оруулж буй голлох татварын хэмжээ нь 553,4 тэр бум төгрөг байна. Үүнээс зарим голлох татвар, төлбөрүүдийн хэмжээг харуулвал: /Үндэсний статистикийн хорооны эх сурвалжаар/

Хүснэгт-3

Уул уурхайн салбараас улсын төсөвт төлсөн голлох татварын хэмжээ						
Татвар, төлбөр	Хэмжих нэгж	2006 он	2007 он	2008 он	2009 он	2010 оны 11 сарын байдлаар
Зарим бүтээгдэхүүний үнийн өсөлтийн албан татвар	сая.төг	177 519,9	352 712,6	384 874,3	186 526,8	374 157,0
Ашигт малтмалын нөөц ашигласны төлбөр	сая.төг	44 894,8	94 388,9	109 115,5	110 407,7	148 797,7
Ашигт малтмалын хайгуулын болон ашиглалтын тусгай зөвшөөрлийн төлбөр	сая.төг	-	-	27 637,6	33 367,2	27 767,2
Улсын төсвийн хөрөнгөөр хайгуул хийсэн ордын нөхөн төлбөр	сая.төг	-	-	5 032,8	2 000,7	2 665,3
Нийт улсын төсөвт оруулсан орлого	сая.төг	222 414,7	447 101,5	526 660,2	332 302,4	553 387,2



2006 оны гүйцэтгэлээр 222 414,7 сая төгрөг, 2007 оны гүйцэтгэлээр 447 101,5 сая төгрөг, өмнөх онтой харьцуулбал 2 дахин их байх ба 2008 онд 526 660,2 сая төгрөг, өмнөх онтой харьцуулбал 117 %-иар их, 2009 онд 332 302,4 сая төгрөг өмнөх онтой харьцуулбал 6 %-иар бага, 2010 оны эхний 11 сарын гүйцэтгэлээр 553 387,2 сая төгрөг өөр өмнөх онтой харьцуулбал 166%-иар нэмэгдсэн ба тус тус улсын нэгдсэн төсөвт хуриатлагдсан байна.

Монгол Улсын хэмжээнд 2009 оны байдлаар 1215 уул уурхайн ашиглалтын тусгай зөвшөөрлөөр 575 685,3 га газрыг ашиглаж байгаа нь уул уурхайн салбар нь манай улсын үйлдвэрлэлийн нэг томоохон салбар болохыг харуулж байна.

Уул уурхайн салбарын бүтээгдэхүүн гаргалт /2004-2010/

Хүснэгт-4

	Бүтээгдэхүүн	2004	2005	2006	2007	2008	2009	2010 XI сар
1.	Бүхэллэг жонш, мян.тн	206.7	233.4	239.4	245.0	219.1	344.2	542.4
2.	Флотацын баяжмал, мян.тн.	102.7	93.7	108.3	109.9	122.3	115.3	149.94
3.	Баяжмал дахь зэс, мян.тн	130.0	126.3	129.7	130.2	126.8	129.8	113.1
4.	Баяжмал дахь молибдени, тн	1141	1153	1403.9	1978.3	1783.6	2408.7	2008.97
5.	Цагаан тугалганы баяжмал /50%, тн	22.0	47.0	-	27.5	87.5	15	13.0
6.	Гянтболдын баяжмал, тн	77.1	78.2	182.2	244.5	141.9	38.6	91.3
7.	Нүүрс, мян.тн	6665	7517.1	8074.1	9237.6	10071.9	14442.1	19231.7
8.	Алт/х.ц./, кг	18500	21900	21267	18087	15184 бохир	9803 бохир	6280.5 бохир



9.	Катодын зэс, тн	2376.1	2474.5	2618.4	3006.5	2586.6	2470.1	2480.5
10.	Төмрийн хүдэр, мян.тн	33.5	167.7	180.0	265.1	1387.4	1379.0	3123.5
11.	Цайрын баяжмал, мян.тн	-	22.8	109.9	154.7	143.6	141.5	99.97
12.	Цувимал зэс, тн	-	195.5	221.2	-	-	-	-
13.	Молибдени исэл, тн	-	-	157.8	2664.0	2112.2	156.5	2367.13
14	Цемент, мян.тн	61.9	111.9	140.8	179.8	269.3	234.8	243.7
15	Шохой, мян.тн	30.0	81.2	60.4	43.35	54.8	43.1	35.2
16	Тоосго, сая ш	12.5	14.6	22.2	20.8	28.9	18.0	
17	Хүнсний давс, тн	258.5	196.7	166.7	4.0	115.0	5.0	

4.2. Монгол Улсын Уул уурхайн салбарын татварын шинэчлэлт


4.2.1 Зарим бүтээгдэхүүний үнийн өсөлтийн албан татварын судалгаа

Монгол улсын хувьд 2006 оноос уул уурхайн салбарт гадаадын хөрөнгө оруулагчид зэс болон алтны томоохон ашигт малтмалын орд газарт хөрөнгө оруулалт хийх хандлага ажиглагдсан бөгөөд дээрхи төрлийн ашигт малтмалын дэлхийн зах зээлийн үнэ нилээд хэмжээгээр үнийн өсөлтөөс шалтгаалж байсан. Үүнтэй уялдуулан уул уурхайн салбарт эцсийн бүтээгдэхүүн үйлдвэрлэлийг дэмжих, нэмүү өртгийг дотооддоо бий болгох, нэмэлт орлогоос тодорхой хэсгийг Монгол Улсын төсөвт төвлөрүүлэх зорилгоор уул уурхайн салбарт “Зарим бүтээгдэхүүний үнийн өсөлтийн албан татварын тухай хууль” хэрэгжиж эхэлсэнтэй уялдан татварын бүтцэд “Зарим бүтээгдэхүүний үнийн өсөлтийн албан татвар” нэртэй шинэ татвар нэмэгдсэн.

Үүгээрээ Монгол Улсын уул уурхайн салбарын хууль эрх зүйн хүрээнд томоохон өөрчлөлт оруулсан билээ.

Мөн 2008 оны 9 сараас дэлхийн зах зээл дэх ашигт малтмалын түүхий эдийн үнэ ханшийн өсөлтүүдээс үүдэн уул уурхайн салбар эрчимтэй хөгжиж Монгол улсын эдийн засагт томоохон байр суурь эзлэх болсон билээ. Харамсалтай нь 2006 оноос хойш болж өнгөрсөн уул уурхайн салбарын бодлогын томоохон өөрчлөлтүүд нь салбарын хөрөнгө оруулалт, үйлдвэрлэл, борлуулалтанд сөргөөр нөлөөлсөн байна.

1990-2009 онуудын алт олборлолтын хэмжээг авч үзвэл:



5-р зураг. Алтны үйлдвэрлэл

Судалгаанаас үзэхэд 2005 онд 24 121,9 кг буюу хамгийн их хэмжээний алт олборлолт явагдсан бөгөөд 2007 оноос Зарим бүтээгдэхүүний үнийн өсөлтийн албан татварын тухай хууль хэрэгжиж эхэлснээр алт олборлолт буурч 2009 онд эрс буурч 9 803,3 кг болсон байна. Үүнээс үзэхэд Зарим бүтээгдэхүүний үнийн өсөлтийн албан


AL	-0.33
NE	-0.07
MV	-0.02
OTVV	-0.32
HYOS	-0.01
PLUG	-1.22%
ESLR	-0.04
LNT	-0.18%
26	-0.01

татварын тухай хууль батлагдан хэрэгжиж эхэлсэнтэй холбоотой байна.

Зарим бүтээгдэхүүний үнийн өсөлтийн албан татварын сөрөг талуудыг дурьдвал хууль батлагдсанаар алт олборлогч олон жижиг, дунд аж ахуйн нэгжүүд дампуурч, бүр зарим нь хууль бус наймаа, гэмт хэргийн сүлжээ, далд эдийн засагт шилжсэн гэж үзэж байна.

Гэвч зарим бүтээгдэхүүний үнийн өсөлтийн албан татвар хэрэгжиж эхэлснээр 2006-2010 оны 11 сарын байдлаар Монгол Улсын төсөвт нийт 1 475 808,6 сая төгрөгний орлого оруулж улс орны эдийн засагт гол үүрэг гүйцэтгэсэн нь эерэг талтай байна.

Уул уурхайн салбарт 2006-2010 онуудын зарим бүтээгдэхүүний үнийн өсөлтийн албан татвар, ашигт малтмалын нөөц ашигласны төлбөрийн улсад оруулсан нийт татвар, төлбөрийн хэмжээ үзүүлбэл: / YCX-ны мэдээллээр/



6-р зураг. Монгол Улсын төсөвт оруулсан татварын хэмжээ

LB	-0.93%
MAL	-0.61%
NE	-0.02%
MV	-0.52%
OTVV	-0.31%
HYOS	-0.32%
PLUG	-0.04%
ESLR	-0.18%
LMT	-1.11%
	-0.04%
11.61	-1.34%
21.19	-0.11%
26.37	-0.04%
62.20	-0.19%
21.77	-0.53%
	-0.04%
26.6	0.66%
	0.0%



Судалгаанаас үзэхэд 2007 онд 447 101,5 сая төгрөг, 2008 онд 493 989,9 сая төгрөг болж өссөөр 2009 онд 296 934,5 сая төгрөг болж даруй 45%-иар буурсан байна. Энэ нь 2008 онд зарим бүтээгдэхүүний үнийн өсөлтийн албан татварын хуулинд өөрчлөлт орж босго үнийг 850 ам доллар болгосонтой холбоотойгоор татварын ачаалал багассан байна.

Иймээс зарим бүтээгдэхүүний үнийн өсөлтийн албан татвар 2011 оноос хүчингүй болж, өсөн нэмэгдэх нөөцийн төлбөрийг шинээр бий болгохтой холбогдуулан Австрали Улсын ашигт малтмалын нөөц ашигласны төлбөрийн судалгааг хийллээ.

4.2.2.Австрали Улсын ашигт малтмалын нөөц ашигласны төлбөр, шинээр хэрэгжиж гарсан ашигт малтмалын нөөц ашигласны төлбөрийн судалгаа

Австралийн Засгийн Газар нь 2010 оны эхээр ашигт малтмалын нөөц ашигласны төлбөрийг өөрчилж шинээр RSPT буюу ашигт малтмалын нөөц ашигласны рентийн төлбөрийг томоохон уул уурхайн компаниудад 40 %-иар ноогдуулахаар болсон.

Гэтэл Австралийн Засгийн Газар уул уурхайн компаниудад оноохоор төлөвлөж байсан маргаантай ашигт малтмалын нөөц ашигласны рентийн төлбөрийн төлөвлөгөөгөө эргэн харах шийдвэр гаргасан байна. Австралийн Ерөнхий сайд Кевин Радд уул уурхайн компаниудад 40 хувийн ашгийн татвар оноох шийд гаргасан байсан юм. Харин түүний залгамжлагч Жулиа Гиллард уул уурхайн салбарынхантай хийсэн хэлэлцээрээр уг татварын хэмжээг нүүрс болон төмрийн хүдрийн уурхайнуудад 30 хувь гэж бууруулж тогтоохоор болсон байна.

16	-0.33	-0.07
23	-0.07	-0.02
NE	-0.01	-0.02
MV	-0.01	-0.02
OTVV	-0.04	-0.18%
HYOS	11.61	-0.54%
PLUG	21.17	-0.34%
ESLR	26.37	-0.01
LNT	62.20	-0.19%
	21.77	-0.04%
	26	0.86%



Харин байгалийн хий, нефтийн үйл ажиллагаа эрхэлдэг компаниуд өмнө нь байсан 40 хувийн татварыг төлсөн хэвээрээ байх болно гэж Засгийн Газар шийдвэрлэжээ. Түүнчлэн 40 хувийн татвар дан ганц далайн эрэг орчим бус эх газарт үйл ажиллагаа явуулж байгаа компаниудад ч хамаардаг болсон байна. Харин жилд 46 сая австрали доллараас бага орлоготой төмрийн хүдрийн болон нүүрсний уурхайнууд шинэ татвараас чөлөөлөгдөхөөр болжээ.

Хэдийгээр ийнхүү уул уурхайн салбарынхны зүгээс ширүүн эсэргүүцэлтэй тулаад байсан 40 хувийн татварыг бууруулсан ч Засгийн Газарт олон тэрбум ам.долларын нэмэлт орлого орох болно гэж Австралийн Засгийн Газар үзэж байна.

Энэ оны эхээр ноён Радд татварын төлөвлөгөөгөө зарлахдаа 40 хувийн татвар ноогдуулснаар жилд 9 тэрбум австрали долларын орлого нэмж олно гэж ярьж байсан. Шинэчлэн өөрчилсөн төлөвлөгөө түүнээс 1.5 тэрбуунаар бага орлого оруулах болно гэж Австралийн Засгийн газрын эдийн засагчид тооцоолж байна.

Уул уурхайн компаниудын гүйцэтгэх захирлууд энэ шийдвэрийг “нааштай үр дүн” гэж хүлээж авч байна. Экс ерөнхий сайд Раддыг 40 хувийн татварын төлөвлөгөөгөө зарласны дараа уул уурхайн нүсэр том “BHP Billiton”, “Rio Tinto” зэрэг компаниуд экс сайдын эсрэг хүчтэй лобби хийж эхэлсэн бөгөөд хэт өндөр татвар авах нь эдийн засгийн өсөлтөнд сөрөг нөлөө үзүүлэх болно гэж анхааруулж байсан юм.

Ашигт малтмалын нөөц ашигласны төлбөр нь уул уурхайн төслүүд дээр шийдвэр гаргахад их чухал хүчин зүйл болдог бөгөөд аль муж нь шинээр уул уурхайн төслүүдэд хөрөнгө оруулах үйл ажиллагааны таатай нөхцлийг хангаж буйг тодорхойлно.

LB	-0.93	-0.7%
MAL	-0.07	-0.0%
NE	-0.52	-1.5%
MV	-0.31	-3.2%
OTVV	-0.04	-1.1%
HYOS	-0.05	-1.3%
PLUG	-0.11	-0.5%
ESLR	-0.04	-0.4%
LMT	-0.05	-1.1%
	21.19	0.01
	26.37	-0.01
	62.20	-0.04%
	21.77	0.53
	26.6	0.13



Хэрэв холбооны засгийн газрын санал болгосноор муж бүрийн Ашигт малтмалын нөөц ашигласны төлбөрийн тогтолцоог холбооны засгийн газрын ашигт малтмалын нөөц ашигласны түрээсийн төлбөрөөр солих бол Ашигт малтмалын нөөц ашигласны төлбөрийг яж ноогдуулж буйг цаг тутам хянаж, Австралийн хэмжээнд түвшинг үнэлж дүгнэх болно.

Ашигт малтмалыг олборлоход ноогдуулж буй төлбөрийг тухайн газарт буй ашигт малтмалыг өмчлөгч муж болон орон нутгийн засгийн газар хариуцна. Ихэнхи тохиолдолд Ашигт малтмалын нөөц ашигласны төлбөр нь ашигт малтмалын үнэлгээнд үндэслэн тэнцэх хувиар ба тоо хэмжээнээс /бүтээгдэхүүн тус бүрт тогтмол ханш/ хамаарч төлөгдөнө. Харин хойд бүсийн нутагт ашигт малтмалын нөөц ашигласны төлбөр нь ашигт малтмалаас орох ашигт үндэслэн тодорхойлогдоно. Энэхүү системийн дагуу уул уурхайн үйлдвэрлэлийн цэвэр орлогод нийцүүлж ашигт малтмалын нөөц ашигласны төлбөрийг тооцно. Ихэнхи жижиг уурхайн үйл ажиллагаа энэхүү татварын тогтолцооноос чөлөөлөгддөг бөгөөд эхний 50 000 ам долларын цэвэр орлогод татвар ноогдуулдаггүй.

Одоогийн Queensland-ийн систем нь тогтмол хувь болох 2,7% болон хувьсах хувь /1,5%-4.5%/ хоёрын аль нэгийг ашигт малтмалын үнэнд тохируулан сонгох боломжийг хүмүүст олгодог онцлогтой. Энэхүү сонгох боломж нь зөвхөн тодорхой хэдэн ашигт малтмалд¹ үйлчлэх бөгөөд 2011 оны 1-р сарын 1-ний өдрөөс эхлэн хүчингүй болж түүнээс хойш зөвхөн хувьсах үнэ үйлчилнэ.

Queensland-ийн засгийн газар 2008-2009 оны төсөвтөө 2 үе шат бүхий нүүрсний ашигт малтмалын нөөц ашигласны төлбөрийн бүтцийг шинээр оруулж энэ нь 2008 оны 7-р сарын 1-ний өдрөөс үйлчилж байна. Энэ шинэ бүтэц нь олборлосон нүүрсний үнэ 1 тоннд 100\$-оос илүү тохиолдолд ашигт малтмалын нөөц ашигласны төлбөрийн



хэмжээг 7-10%-иар өсгөсөн. Жишээ нь хэрвээ тухайн улиралд дундаж нүүрсний үнэ 1 тоннд 150\$ бол ашигт малтмалын нөөц ашигласны төлбөрийн хэмжээ нь эхний 100\$-т 7% үлдсэн 50\$-т 10% байна.

Хямарч буй эдийн засгийн нөлөөгөөр энэхүү ашигт малтмалын нөөц ашигласны төлбөрийн хэмжээг илүү тогтвортой, урьдчилж хэмжиж болохуйц болгох хэрэгтэй болж байна. Queensland-д саяны болсон сонгуулиас өмнө 2 хүчний намууд ашигт малтмалын нөөц ашигласны төлбөр, татварын хэмжээг цаашид нэмэхгүй гэж амласан.

Шинэ Өмнөд Wales-ын нүүрсний уурхайд ашигт малтмалын нөөц ашигласны төлбөрийн тогтолцоог 2004 онд нягталж судласны үндсэн дээр ач холбогдол бүхий өөрчлөлтүүд хийгдсэн. Үүнд шинээр бүтээгдэхүүний үнэлгээнд тэнцэх аргад тулгуурласан татвараар өмнөх тоо хэмжээнд тулгуурласан янз бүрийн уурхайд² ногдуулах З-н төрлийн татварыг халсан. Энэ тогтолцоо нь Шинэ Өмнөд Wales-ийн эрдэс баялгийн зөвлөлөөс ихээхэн төвөгтэй, хэрэгжүүлэхэд хэцүү гэсэн шүүмжлэл хүртсэн. Queensland ийнхүү 100\$-оос илүү бүтээгдэхүүний үнэлгээтэй нүүрст ногдуулах ашигт малтмалын нөөц ашигласны төлбөрийн хэмжээг өсгөж, Шинэ Өмнөд Wales-ийн Засгийн Газар бүх түвшинд нүүрсэнд ногдуулах ашигт малтмалын нөөц ашигласны төлбөрийг 1,2%-иар 2009 оны 1-р сарын 1³-ний өдрөөс өсгөжээ.

Сүүлийн жилд Баруун Австрали, Өмнөд Австрали ч бас ашигт малтмалын нөөцөд ногдуулах төлбөрийн хувь хэмжээг дахин авч хэлэлцсэн. Баруун Австралийн 2005 оны 7-р сарын 1-ний өдрөөс үйлчилж эхэлсэн шинэчлэгдсэн татварын тогтолцоо нь 1 тоннд 30% ба 1 тоннд тогтмол 50% байхаар хэрэглээний бүтээгдэхүүний үнэ өсч буйтай уялдуулжээ. 2010 оны 7 сарын 1-ний өдрөөс хойш тогтмол хувь нь металл бус ашигт малтмалын бүтээгдэхүүний үнийн индекс дээр үндэслэгдэн бодогдож байна.

LB	-0.93%
MAL	-0.61%
NE	-0.07%
MV	-0.52%
OTVV	-1.58%
HYOS	-0.31%
PLUG	-3.22%
ESLR	-0.04%
LMT	-1.18%
	-0.34%
11.61	-0.05%
21.19	-0.11%
26.37	-0.04%
62.20	-0.19%
21.77	-0.53%
26.6	-0.86%



Өмнөд Австралид “Шинэ уурхай” гэсэн статустайгаас бүх ашигт малтмалын тусгай зөвшөөрөл эзэмшигчдэд ашигт малтмалын нөөц ашигласны төлбөр нь 3,5%-аар тооцогдоно. Гэхдээ шинээр батлагдсан “Шинэ уурхай” гэсэн статустай уурхайнуудын хувьд ашигт малтмалын нөөц ашигласны төлбөрийн хэмжээ нь 5 жилийн турш 1,5% байна.

